



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 07 өдөр

Дугаар А/272

Чингис хот

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29,1-ийн "а", Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.20, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Засгийн газрын 45 дугаар тогтоолоор батлагдсан коронавируст халдвар (ковид-19)-ын тархалтын түвшинг тогтоож, төрийн байгууллага, хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг зохицуулах түр журам"-ын хэрэгжилтийг хангах, иргэдийн болон тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг зогсоох зорилгоор "Хэнтий аймгийн төв Чингис хотыг бүсчлэн хаах төлөвлөгөө"-ний хэрэгжилтийг хангах, хяналтын 11 постыг 2021 оны 5 дугаар сарын 25-ны өдрөөс 2021 оны 6 дугаар сарын 02-ны өдрийг хүртэл 7 хоногийн хугацаанд 23, мөн 2021 оны 6 дугаар сарын 03-ны өдрөөс 2021 оны 7 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл 29 хоног хяналтын 2 цэгт үүрэг гүйцэтгэх 5 алба хаагч, аймгийн "Шуурхай штаб"-ын хоногт ажиллах 5 алба хаагчдын хоол, автомашины шатах тослох материал болон бичиг хэрэг, холбооны зардлыг нэгдүгээр, Цэнхэрмандал сумын "Дэлүүн болдог" хяналт-шинжилгээний цэгт 2021 оны 5 дугаар сарын 25-ны өдрөөс 2021 оны 7 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл 38 хоногийн хугацаанд үүрэг гүйцэтгэх 18 алба хаагчдын хоол, байр, шатахуун болон холбоо, бичиг хэргийн зардлыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Урьдчилан сэргийлэх, халдварын тархалтын түвшинг тогтооход үүрэг гүйцэтгэх алба хаагчдын ажиллах нөхцөл бололцоог сайжруулахад шаардагдах 29.099.000 (хорин есөн сая ерэн есөн мянга) төгрөгийг аймгийн Гамшгийн эрсдэлийг бууруулах сангаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д зөвшөөрсүгэй.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Ц.Чогсомжав)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



ЦИДЭРБАТ

231010464

06 Аймгийн Засаг даргын 2021 оны
..... дугаар сарын.....өдрийн
дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт



ЗАРДЛЫН ТООЦОО

Байгууллагын нэр	ЗАРДЛЫН НЭР ТӨРӨЛ				Дүн
	Шатахууны зардал	Бичиг хэргийн зардал	Хоолны зардал	Холбооны зардал	
Цагдаагийн газар	2.092.500	250.000	6.120.000	748.000	9.210.500
Онцгой байдлын газар		495.000	3.800.000		4.295.000
ДҮН	2.092.500	745.000	9.920.000	748.000	13.505.500

Аймгийн Засаг даргын 2021 оны
06 дугаар сарын 07 өдрийн А/272
дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт



ЗАРДЛЫН ТООЦОО

Байгууллагын нэр	ЗАРДЛЫН НЭР ТӨРӨЛ				Дүн
	Шатахууны зардал	Бичиг хэргийн зардал	Хоолны зардал	Байрны зардал	
Цагдаагийн газар	883.500	130.000	13.680.000	900.000	15.593.500
ДҮН	883.500	130.000	13.680.000	900.000	15.593.500